



**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2026 02 06
оны сарын өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

**ЭХЭМҮТ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах
журам батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, ЭХЭМҮТ-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ЭХЭМҮТ-ийн “Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Тасаг, нэгж, албадын эрсдэлийн багийн бүрэлдэхүүн”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж батлуулахыг ЭМТҮЧАБА-ны дарга /А.Оюунчимэг/, ХНА-ны дарга /Б.Мөнхшүр/ нарт даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЭМТҮЧАБА-ны дарга /А.Оюунчимэг/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

Ж.ОТГОНБААТАР

1606060127

Захирлын 2026 оны ... дугаар сарын ... ны
өдрийн ... тоот тушаалын ... дугаар хавсралт



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь үйлчлүүлэгчид чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг цаг тухайд нь үзүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанаас хамаарч гарах эмнэлзүйн болон эмнэлзүйн бус эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.
- 1.2. Төв нь эрсдэлийн үнэлгээ хийхдээ ЭМС-ын 2019 оны А/566 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг удирдлага болгоно.
- 1.3. Эрсдэлийн удирдлагын хорооны дарга нь төвийн Захирал бөгөөд төвийн захирлын эзгүйд ЭМТҮЧАБА-ны дарга орлоно.
- 1.4. Эрсдэлийн удирдлагын хороо нь эмнэлэг, тасаг нэгж, албадуудыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангана.
- 1.5. Эрсдэлийн удирдлага гэдэг нь тухайн байгууллагад тохиолдож болох аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох хүчин зүйлсийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгах, шилжүүлэх, нэгэнт аюул осол, эрсдэл нүүрлэсэн тохиолдолд түүнийг хохирол багатайгаар даван туулах, ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс ангид байх цогц үйл ажиллагаа юм.
- 1.6. Эрсдэлийн удирдлагын хороо нь тасаг нэгж, албадуудын эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, ажилтнуудыг сургах үүрэгтэй.
- 1.7. Эмнэлэг, тасаг, нэгж, албадууд өөрийн үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болох эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан нэгтгэж мөрдөнө.

ХОЁР. Журмын хамрах хүрээ, ажиллах зарчим

- 2.1. Энэхүү журам нь төвийн бүх алба, тасаг, нэгжийг хамарсан байна.
- 2.2. “Эрсдэлийн удирдлагын хороо”-нд удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг төлөөллийг оролцуулна.
- 2.3. Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлсон байна.
- 2.4. Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүд нь байгууллагын нөхцөл байдал, эмнэлзүйн болон эмнэлзүйн бус эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох, түүнд дүн шинжилгээ хийж, учирч болох аюул, эрсдэлийн талаарх бодлого, журам боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.5. Эрсдэлийг үнэлэх, бууруулах, арилгах, төлөвлөгөө боловсруулахад харилцан зөвшилцөх зарчмыг баримтлан ажиллана.

ГУРАВ. Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн чиг үүрэг

3.1. Төвийн эрсдэлийн удирдлагын хороо нь дараах үүрэг хүлээнэ.

3.1.1. Байгууллагын гадна болон дотоод орчин, эмнэлзүйн эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлон батална.

3.1.2. Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн чиг үүргийг тодорхойлж үүрэгжүүлнэ.

3.1.3. Тасаг нэгж, албадуудын эрсдэлийн багийн үйл ажиллагаанд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын багийн чиг үүрэг, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн үнэлгээ хийнэ.

3.1.4. Эрсдэлийн удирдлагын талаар хэрэгжүүлсэн тайланг хэлэлцэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

3.2. Байгууллагын Захирал нь:

3.2.1. Захирал нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрсдэлийн удирдлагатай холбоотой бүх шийдвэр, тушаалыг биелүүлэх, эрсдэлийн удирдлагын журмыг дагаж мөрдөх, эрсдэлийн менежмент, аюулгүй ажиллагааны тогтолцоог үр дүнтэй ажиллуулах үүрэг хүлээнэ.

3.2.2. Захирал нь төлөвлөгөөнд заасны дагуу жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдэлийн удирдлагын талаар тусган үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.3. Төлөвлөгөөнд тухайн байгууллагын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ, орчин нөхцөлөөс шалтгаалан эрсдэлийн удирдлагын зорилго, зорилтуудыг тодотгон, тулгарч буй эрсдэлтэй холбоотой шийдвэрлэх арга зам, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны санхүү хөрөнгийн эх үүсвэр, хамтрагч талууд, тэдгээрийн ажлын гүйцэтгэлд тус тус хяналт тавина.

3.2.4. Захирал нь эрсдэлийг бусад талуудтай хамт үүрэх, эрсдэлийг шилжүүлэх үүднээс байгууллагын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг даатгуулах шийдвэр гаргана.

3.2.5. Эрсдэлийн менежментийн цар хүрээ, үйл явцад гүйцэтгэлийн түвшин шаардлагатай буюу хүлээгдэж байгаа хэмжээнд байгаа эсэхийг тогтоох зорилгоор нөхцөл байдлыг тодорхойлох буюу ажиглах, зөвлөх, тогтмол шалгалт хийх мониторингийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.

3.3. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга нь:

3.3.1. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга нь Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн бөгөөд Захирлын өмнө санхүүгийн эрсдэлийн удирдлага, түүнд тавих хяналтын үйл ажиллагааг хариуцан ажиллана.

3.3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны нээлттэй байдал, нягтлан бодох бүртгэлийн механизмаар хянадаг тогтолцоотой байх, хяналт хийх үүрэг хүлээнэ.

3.4. Сувилахуйн албаны дарга нь:

3.4.1. Сувилахуйн албаны дарга нь эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн бөгөөд Захирлын өмнө сувилахуйн тусламж, үйлчилгээний эрсдэлийн удирдлагын үйл явцыг хариуцан ажиллана.

3.4.2. Байгууллагын эрсдэлийн удирдлагын зохицуулалтыг хангахад ахлах сувилагч нарт тодорхой чиглэл өгч ажиллана.

3.4.3. Сувилахуйн албаны дарга нь хариуцсан үйл ажиллагааныхаа хүрээнд

эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд сувилахуйн тусламж, үйлчилгээний тохиолдол, ноцтой үйл явдлаас үүдэн гарах эрсдэлийг зохих ёсоор удирдаж, тайлагнах, үйл явцыг төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

3.4.4. Сувилахуйн албаны дарга нь алдаанаас суралцах тогтолцоог ханган ажиллаж, өөрсдийн үйл ажиллагааны чиглэл дэх эрсдэлийг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бууруулах, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.

3.5. Тасаг/нэгжийн дарга, эрхлэгч нь:

3.5.1. Тасаг/нэгжийн дарга, эрхлэгч нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол, эрсдэл бүртгэх, мэдээлэх журамд заасны дагуу хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг өөрийн удирдаж буй нэгж дээр гардан хэрэгжүүлж, дахин давтагдахаас сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ авна.

3.5.2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол, эрсдэл бусад тасаг/нэгжид тохиолдох үед эрсдэлээс сэргийлэх үүднээс мэдээлэл, туршлагаа хуваалцах үйл ажиллагааг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албатай хамтран хэрэгжүүлнэ.

3.5.3. Өөрсдийн хариуцсан нэгжийн хүрээнд өртөж болзошгүй эрсдэлийг бүртгэн мэдээлж, эрсдэлийн үнэлгээ хийн арилгах, бууруулах арга хэмжээг Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежертэй хамтран төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.5.4. Хариуцсан нэгжийн хэрэгжүүлж чадах эрх мэдлээс хэтэрсэн удирдах боломжгүй эрсдэлийн талаар эрсдэлийн хороо, удирдлагад шуурхай мэдээлнэ.

3.6. Ажилтнууд нь:

3.6.1. Байгууллагын бүх ажилтнууд эрсдэлийн удирдлагыг байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ гэж ухамсарласан байна.

3.6.2. Хувь хүний (өвчтөн, ажилтан, гэрээт ажилтан гэх мэт) эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйл ажиллагааг өөрсдийн хариуцсан удирдлагадаа эрсдэл, тохиолдол мэдээлэх хуудсыг бөглөн мэдээлэх үүрэг хүлээн мэдээлнэ.

3.6.3. Хэрэв эрсдэл мэдээлсний дагуу ямар нэгэн хариу үйлдэл хийгдэхгүй байвал захиргааны удирдлагад шууд мэдээлнэ.

3.6.4. Өөрсдийн гүйцэтгэж буй ажилд шаардагдах хувийн хамгаалах хэрэгсэл, тодорхой тэмдэглэгээ ашиглах гэх мэт аюулгүй ажиллагааны зохицуулгуудыг дагаж мөрдөнө.

3.7. Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер нь:

3.7.1. Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер нь байгууллагын эрсдэлийн багийн гишүүдтэй хамтран үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдалтай холбоотой гадаад, дотоод орчны эрсдэл, эмнэлзүйн эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулна.

3.7.2. Байгууллагын өдөр тутмын үйл явц, дотоод болон гадаад орчны талаар эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг хянах, бууруулах, арилгах зорилгоор байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөнд шинэчлэл хийх санал, төслийг боловсруулан, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна.

3.7.3. Байгууллагын удирдлагын хороонд эрсдэлийн багийн үйл ажиллагааны

талаар удирдлагад тайлагнана.

3.7.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой аюул, эрсдэлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээг баримтжуулан дүн шинжилгээ хийж түгээн дэлгэрүүлнэ.

3.7.5. Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу эрсдэлийн багийн үйл ажиллагааг холбогдох нэгжүүдтэй уялдуулах ажлыг зохион байгуулна.

3.7.6. Барилга байгууламжийн засвар үйлчилгээний өмнө, засварын явцад, засварын дараа гарч болох эрсдэл гэх мэт гадаад болон дотоод орчны эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг эрсдэлийн багтай хамтран урьдчилан төлөвлөж шийдвэрлэж хэвшүүлнэ.

3.7.7. Эрсдэлийг бүртгэх, үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах талаар байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулна.

3.7.8. Шаардлагатай баримт бичгийг хөтөлж, эрсдэлийн удирдлагын хорооны хурлыг улирал тутам зохион байгуулна.

ДӨРӨВ. Хяналт үнэлгээ

4.1. Байгууллагын өдөр тутмын үйл явц, дотоод болон гадаад орчны талаар эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг хянах, бууруулах зорилгоор төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна.

4.2. Эрсдэлийн үнэлгээг, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн байгууллагын хяналт үнэлгээг мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хийлгүүлнэ.

4.3. Тасаг нэгжийн эрсдэлийн баг дотоодын хяналт үнэлгээг хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой аюул, эрсдэлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээг баримтжуулан дүн шинжилгээг улирал тутам байгууллагын удирдлагын хороонд танилцуулна.

ТАВ. Нэр томъёоны тайлбар

5.1. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- Эрсдэл: Үйлчлүүлэгч ба эрүүл мэндийн байгууллага аюул заналд өртөж болох магадлал
- Эмнэлзүйн эрсдэл: Тухайн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч, эрүүл мэндийн ажиллагсдад учирч болох амь насанд аюултай тохиолдол (гэмтэл, осол) гарах магадлал
- Эмнэлзүйн бус эрсдэл: Тухайн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны аюулгүй байдалд үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдэд учирч болох тохиолдол (гэмтэл, осол) гарах магадлал
- Эрсдэлийн үнэлгээ: Эрсдэлийн түвшинг тоон утгаар илэрхийлэгч үндсэн гол хэмжүүр нь магадлал болон үр дагавар юм. Магадлал нь үзэгдэх давтамжаар, харин үр дагаврыг үзүүлэх нөлөөлөл, хохирлоор хэмжинэ.
- Эрсдэлийн удирдлага гэдэг нь тухайн байгууллагад тохиолдож болох аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох хүчин зүйлсийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгах, шилжүүлэх, нэгэнт аюул осол, эрсдэл нүүрлэсэн

тохиолдолд түүнийг хохирол багатайгаар даван туулах ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс ангид байх цогц үйл ажиллагаа юм.

- Эрсдэлийг арилгах: Тухайн эрүүл мэндийн байгууллагад эрсдэл учруулах үйл ажиллагааг зогсоох, эрсдэлээс зайлсхийх тодорхой арга зам нэвтрүүлэх замаар эрсдэлийг арилгана.
- Эрсдэлийг бууруулах, багасгах: Тухайн эрүүл мэндийн байгууллага эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулна.
- Эрсдэлийг шилжүүлэх: Тухайн эрүүл мэндийн байгууллага эрсдэлээ даатгуулах юм уу өөр арга зам ашиглах замаар байгууллага/хэсэг бүлэг хүнд шилжүүлдэг.
- Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх: Эрсдэлээс үүдэн гарах хохирол, алдагдлыг тухайн эрүүл мэндийн байгууллага өөрөө хариуцна гэж үзэн тодорхой эрсдэлийг хүлээн зөвшөөрдөг.

06

Захирлын 2026 оны дугаар сарын
-ны өдрийн тоот тушаалын дугаар хавсралт



ЭХЭМҮТ-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	ЭХЭМҮТ-ийн захирал
Нарийн бичгийн дарга:	Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер
Гишүүд:	Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал
	Хүүхдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
	Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
	Сувилахуй эрхэлсэн дэд захирал
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга
	Хүний нөөцийн албаны дарга
	Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны дарга
	Хангамж үйлчилгээ, инженер техник, хоол үйлдвэрлэлийн албаны дарга
	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан
	Төвийн Халдварын сэргийлэлт, хяналтын албаны нарийн бичгийн дарга
	Эмзүйн албаны дарга
	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга
	Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн
	Төвийн Ёсзүйн салбар хорооны дарга
	Төвийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

ин 2026 оны сарын
рт тушаалын р хав

НЭГ. Дэмжлэгт удирдлага:

- Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
2. Цусны эмгэг, хавдар судлалын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
3. Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
4. Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
5. Мэдрэлийн эмгэг судлалын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
6. Бөөр, дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
7. Сэргээн засах эмчилгээний тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
8. Нярайн эмгэг судлалын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
9. Нярайн эрчимт эмчилгээний тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
10. Дутуу нярай, гүйцэт нярайн эрчимт эмчилгээний тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Их эмч
Их эмч
Ахлах сувилагч
11. Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч

12. Яаралтай тусламжийн тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
13. Хүүхдийн зөвлөх поликлиник:
Багийн ахлагч: Поликлиникийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
14. Өсвөр үеийн клиник:
Багийн ахлагч: Клиникийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
15. Радиологийн тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах техникч
16. Бөөрний мэс заслын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
17. Нүдний мэс заслын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
18. Чих хамар хоолойн мэс заслын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
19. Эрүү нүүрний мэс заслын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
20. Ерөнхий мэс заслын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
21. Мэс заслын эрчимт эмчилгээний тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч
22. Цээжний мэс заслын тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Их эмч
Ахлах сувилагч

23. Мэдрэлийн мэс заслын тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Сувилагч

24. Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

ГУРАВ. Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг:

1. Төрөх тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах эх баригч

2. Төрсний дараах тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Эх баригч

Ахлах сувилагч

3. Эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

4. Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

5. Дутуу тээлт судлалын тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах эх баригч

6. Яаралтай тусламжийн тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

7. Эрчимт эмчилгээний тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

8. Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

9. Сэргээн засах эмчилгээний тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Ахлах сувилагч

Сувилагч

10. Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник:

Багийн ахлагч: Поликлиникийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

11. Үргүйдэл, нөхөн үржихүйн төв

Багийн ахлагч: Төвийн эрхлэгч

Гишүүд: Эмбриологч

Ахлах сувилагч

12. Эмэгтэйчүүд, дотоод шүүрэл, эрүүл мэндийг дэмжих тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах сувилагч

ДӨРӨВ. Үйл ажиллагаа, төлөвлөлт:

1. Эдийн засаг, төлөвлөлт, даатгалын алба:

Багийн ахлагч: Албаны дарга

Гишүүд: ЭМД-ын нягтлан бодогч

ЭМД-ын их эмч

2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба:

Багийн ахлагч: Албаны дарга

Гишүүд: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

Хүчилтөрөгчийн станцын цэнэглэгч

3. Эмзүйн алба:

Багийн ахлагч: Албаны дарга

Гишүүд: Эмнэлзүйн эм зүйч

Эм олгогч, эм зүйч

4. Нэгдсэн лабораторийн тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах лаборант

5. Ариутгал, халдваргүйтгэлийн тасаг:

Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч

Гишүүд: Тархвар судлаач

Ахлах ариутгагч

6. Анагаахын удамзүйн лаборатори:

Багийн ахлагч: Лабораторийн эрхлэгч

Гишүүд: Их эмч

Ахлах лаборант

7. Мэдээлэлийн технологийн алба:

Багийн ахлагч: Албаны дарга

Гишүүд: Мэдээллийн технологийн инженер

Мэдээллийн технологийн инженер

8. Үйлчлүүлэгчийг дэмжих тасаг:
Багийн ахлагч: Тасгийн эрхлэгч
Гишүүд: Сэтгэлзүйч
Зөвлөгөө мэдээллийн ажилтан
9. Хангамж үйлчилгээ, инженер техник, хоол үйлдвэрлэлийн алба:
Багийн ахлагч: Албаны дарга
Гишүүд: ХАБЭ ажилтан
Менежер
Хангамж үйлчилгээний зохицуулагч
Хангамж үйлчилгээний зохицуулагч

Төвийн хэмжээнд эрсдэлийн баг нийт 52.

Чанарын менежер М.Камара:

Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг (хариуцаж буй төсөвт ор 254, төсөвт оргүй тасаг, нэгж 4):

1. Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник /кабинетын тоо 12/
2. Яаралтай тусламжийн тасаг /оргүй/
3. Эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг /64/
4. Дутуу тээлт судлалын тасаг /25/
5. Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг /34/
6. Эмэгтэйчүүд, дотоод шүүрэл, эрүүл мэндийг дэмжих тасаг /36/
7. Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасаг /оргүй/
8. Эрчимт эмчилгээний тасаг /9/
9. Төрсний дараах тасаг /74/
10. Төрөх тасаг /12/
11. Сэргээн засах эмчилгээний тасаг /оргүй/
12. Үргүйдэл, нөхөн үржихүйн төв /оргүй/

Чанарын менежер Э.Батцэцэг:

Хүүхдийн эмнэлэг /хариуцаж буй төсөвт ор 312, төсөвт оргүй тасаг, нэгж 4 /

1. Амьсгалын эрхтэний эмгэг судлалын тасаг /40/
2. Бөөр, дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг /40/
3. Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасаг /23/
4. Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг /12/
5. Нярайн эрчимт эмчилгээний тасаг /12/
6. Нярайн эмгэг судлалын тасаг /45/
7. Дутуу нярай, гүйцэт нярайн эрчимт эмчилгээний тасаг /15/
8. Цусны эмгэг, хавдар судлалын тасаг 30, хөнгөвчлөх хэсэг 5 /35/
9. Хоол боловсруулах эрхтэний эмгэг судлалын тасаг /23/
10. Мэдрэлийн эмгэг судлалын тасаг /40/
11. Хүүхдийн зөвлөх поликлиник /оргүй, кабинетын тоо 41/

12. Радиологийн тасаг /оргүй, кабинетын тоо 10/
13. Яаралтай тусламжийн тасаг /3/
14. Сэргээн засах эмчилгээний тасаг /оргүй/
15. Өсвөр үеийн клиник /оргүй/

Чанарын менежер Б.Хишигмаа:

Хүүхдийн эмнэлэг /хариуцаж буй төсөвт ор 175, төсөвт оргүй тасаг, нэгж 1/

1. Ерөнхий мэс заслын тасаг /41/
2. Цээжний мэс заслын тасаг /12/
3. Эрүү, нүүрний мэс заслын тасаг /20/
4. Чих, хамар хоолойн мэс заслын тасаг /32/
5. Бөөрний мэс заслын тасаг /20/
6. Нүдний мэс заслын тасаг /20/
7. Мэс заслын эрчимт эмчилгээний тасаг /6/
8. Мэдрэлийн мэс заслын тасаг /24/
9. Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасаг /оргүй/

Эрсдэлийн менежер С.Дуламжав:

Эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцааны салбар, эмнэлгийн дэмжих үйлчилгээний алба, тасаг, нэгжүүд:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал эрсдэлийн алба
2. Хүний нөөцийн алба
3. Санхүү нягтлан бодох бүртгэлийн алба
4. Эрдэм шинжилгээ, гадаад харилцааны алба
5. Тандалт судалгаа, статистикийн алба
6. Нийгмийн эрүүл мэнд, сургалт, маркетингийн алба
7. Сувилахуйн алба
8. Эдийн засаг, төлөвлөлт, даатгалын алба
9. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба
10. Эмзүйн алба
11. Нэгдсэн лабораторийн тасаг
12. Ариутгал, халдваргүйтгэлийн тасаг
13. Анагаахын удамзүйн лаборатори
14. Мэдээллийн технологийн алба
15. Үйлчлүүлэгчийг дэмжих алба
16. Хангамж үйлчилгээ, инженер техник, хоол үйлдвэрлэлийн алба
 - 16.1. Инженер техникийн хэсэг
 - 16.2. Хоол үйлдвэрлэлийн хэсэг
 - 16.3. Нийтлэг үйлчилгээ, аж ахуйн хэсэг

ТӨГСӨВ.